



БУМАН ОД ПИКЕТ ХХК
Авто зам, замын байгууламжийн
зураг төсөл

Зургийн шифр : 01/24

**ТӨСЛИЙН НЭР: ТӨВ АЙМГИЙН БАЯНЧАНДМАНЬ СУМЫН
ТӨВИЙН ДОТОРХИ ГЭР ХОРООЛОЛ ЧИГЛЭЛИЙН 1.2 КМ ХАТУУ
ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМ**

ТАЙЛБАР БИЧИГ

ЗАХИРАЛ:  Б.БАТЦЭЦЭГ
ЗУРГИЙН ИНЖЕНЕР :  Б.ЦЭРЭН-ОЧИР



УЛААНБААТАР 2024



№	ГАРЧИГ	ХУУДАС
	НЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	2
1.1	Оршил	2
1.2	Зураг төсөл боловсруулах үндэслэл	2
1.3	Зураг төслийг боловсруулахад мөрдөлөг болгосон норм, стандартууд	3
1.4	Зураг төслийн товч танилцуулга, бүрэлдэхүүн	4
1.5	Төслөлтийн үндсэн үзүүлэлтүүд	5
	ХОЁР. ХЭЭРИЙН ХАЙГУУЛ, ХЭМЖИЛТ, СУДАЛГААНЫ АЖИЛ	7
2.1	Төслийн бүс нутгийн уур амьсгал, цаг уурын байдал	7
2.1.1	Замын зурвасын байршил	7
2,1,2	Газрын гадрагын хотгор гүдгэрийн байдал	7
2,1,3	Зам, цаг уурын амьсгал	7
2,1,4	Агаарын температур	8
2,1,5	Хөрсний температур	8
2.3	Замын дагуух буурь хөрсний судалгаа	
	ГУРАВ. ТРАССЫН СОНГОЛТ	11
3.1	Трассын боломжит газрын судалгаа, байршил тогтоох	11
	ДӨРӨВ. ГЕОДЕЗИЙН ХЭМЖИЛТ, СУДАЛГАА	
4,1	Инженер геодези	12
4,2	Инженер геологи	12
	ТАВ. ЗАМЫН ДАГУУ БА ХӨНДЛӨН ОГТЛОЛЫН ТӨЛӨВЛӨВЛӨЛТ, ЭЛЕМЕНТҮҮД	12
5,1	Авто замын зорчих хэсгийн төлөвлөлт	12
	ЗУРГАА. ЗАМЫН ТОНОГЛОЛ, ТЭМДЭГЖҮҮЛЭЛТ	
6,1	Замын тоноглол, тэмдэг, тэмдэглэгээ	14
6,2	Авто замын гарц	14
	ДОЛОО. БУСАД ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ	
7,1	Инженерийн шугам сүлжээ	15
7,2	Археологийн тандалт сүлжээ	15
	НАЙМ. ГАЗАР ЧӨЛӨӨЛӨЛТ	15
	ЕС. АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ	16
	АРАВ. ХАВСРАЛТУУД	17

НЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 ОРШИЛ

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчидийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 4-ны өдрийн XVII дугаар хуралдааны 03 дугаар тогтоолын 3-р хавсралтын “Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-д тусгагдсаны дагуу Төв аймгийн Баянчандмань сумын төвийн гэр хорооллын чиглэлийн авто замын инженерийн нарийвчлсан зураг төсөл”-ийг 2024 оны 2 дугаар сард боловсруулав.

1.2 ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ

- Хөрөнгө оруулалтын эх үүсвэр /аймгийн замын сангийн хөрөнгө оруулалт/
- Төв аймгийн Засаг даргын тамгын газрын 2024 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн №ЗД-2024-01 дугаартай баталсан Төв аймгийн Баянчандмань сумын төвд баригдах авто замын инженерийн нарийвчлсан зураг төсөл боловсруулах даалгавар.

Инженерийн нарийвчлсан зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд дараах ажлууд хийгдсэн болно.

- Авто замын хайгуулын ажлын геодезийн хэмжилт, зураглалын ажлын тайлан
- Авто замын зурвасын инженерийн- геологийн судалгааны тайлан
- Авто замын инженерийн нарийвчлсан зураг төсөл
- Авто замын трасст орсон шугам сүлжээг зайлуулах, шилжүүлэх, өндөрлөх ажлын тоо хэмжээг тодорхойлох
- Зам, замын байгууламжийн барилгын ажлын техникийн шаардлага
- Зургийн тайлбар бичиг
- Ажлын нэгдсэн төсөв

1.3 ЗУРАГ ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХАД МӨРДЛӨГ БОЛГОСОН НОРМ, СТАНДАРТУУД

Төв аймгийн Баянчандмань сумын төвийн гэр хорооллын чиглэлийн авто замын ажлын инженерийн нарийвчлалсан зураг төслийг боловсруулахад Монгол улсын авто замын салбарт мөрдөгдөж байгаа дараах БНБД, норм, стандартуудыг ашиглав. Үүнд:

- Хот тосгоны төлөвлөлт ба барилгажилт БНБД 30-01-04
- Хот суурины гудамж зам төлөвлөх БНБД 32-01-04
- Авто зам төсөллөх ЗЗБНБД 22-004-2016, БНБД 32-01-07
- Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл АЗУАГН 2.01.01-2004
- Тахир дутуу иргэдэд зориулсан, барилгын төлөвлөлтийн нормаль БД31.101.04
- Барилга байгууламжийн буурь суурь БНБД 2.02.01-94
- Авто замын гүүр хоолой төсөллөх БНБД 32-02-12
- Газар хөдлөлтийн бүс нутаг барилга төлөвлөх БНБД 22.01.01*/2006
- Монгол орны инженер-геологийн нөхцлийн зураг М 1:500 000

1.4 ЗУРАГ ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, БҮРЭЛДЭХҮҮН

Төслийн зам нь Төв аймгийн Баянчандмань сумын нутаг дэвсгэрт байрлана. Төлөвлөж буй авто замын трассын эхлэл нь Баянчандмань сумын төвөөс зүүн хойш 1.2км орчим үргэлжилнэ. Улаанбаатар –Дархан чиглэлийн II хэсгийн хатуу хучилттай авто замын км10+620-оос эхлэнэ. Замын трасс нь Баянчандмань сумын төвийн гол авто замын гэр хорооллын урдаас эхлэж хойд хэсгийн арын эгнээнд хүрч дуусна. Төслийн авто зам нь хэвтээ эргэлтийн 14 өнцөгтэй, замын трассын нийт урт 1.274км байна. Зураг 1.4.1 –д байршлын тойм зургийг үзүүлэв.

Зураг 1.4.1 Авто замын байршлын тойм зураг



Замын дагуух нэг төвшингийн гарц 23 цэгт. Ус зайлуулах өөрийн шуудууг замын баруун гар талд төлөвлөж хийж өгсөн. Төслийн авто зам нь мал амьтан, ердийн хөсөг, бага оврын тээврийн хэрэгсэл болон том оврын тээврийн хэрэгсэл зам хөндлөн гарах боломжтой байдлаар төсөллөгдсөн.

Инженерийн шугам сүлжээний хувьд одоо байгаа нарны гэрлээр ажилладаг 33ш гудамжны гэрэлтүүлэг авто замын трасст орсон хэсэгт мэргэжлийн байгууллагаар шилжүүлэн зөөж хамгаалах ажлын тоо хэмжээг гаргуулж төсөвт оруулсан

Төсөлд оролцогч байгууллагууд

- Төв аймгийн засаг даргын тамгын газар
- Замын трассын дагуух инженер геологийн болон материалын орд газрын судалгааг Улаанбаатар -Дархан чиглэлийн авто замын өргөтгөлийн ажлын зураг төслийн геологийн судалгаанаас авч хийв.
- Байр зүйн судалгаа, хэмжилт “Үзэсгэлэнт Тайга” ХХК

Төв аймгийн Баянчандмань сумын төвийн гэр хорооллын чиглэлийн авто замын инженерийн нарийвчлалсан зураг төсөл боловсруулах зураг төслийн иж бүрдэлийг доорх байдлаар багцалсан

ТАЙЛБАР БИЧИГ

Хүснэгт 1.4.1

Зургийн иж бүрдэл		Ботийн дугаар
I	Төв аймгийн Баянчандмань сумын төвийн гэр хорооллын чиглэлийн авто замын инженерийн нарийвчлалсан зураг	Боть-I
II	Тайлбар бичиг	Боть-II
III	Техникийн шаардлага	Боть-III
IV	Авто замын хайгуулын ажлын геодезийн хэмжилт, зураглалын ажлын тайлан	Боть-IV
V	Авто замын зурвас талбайн инженерийн геологийн судалгааны ажлын тайлан	Боть-V
VI	Зам барилгын ажлын төсөв	Боть-VI

1.5 ТӨСӨЛЛӨЛТИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Төв аймгийн Баянчандмань сумын төвийн гэр хорооллын чиглэлийн авто замыг “Авто зам төсөллөх ЗЗБНБД 22-004-2016” нормыг баримтлан төсөллөсөн бөгөөд үндсэн үзүүлэлтийг хүснэгт 1.5.1-д үзүүлэв.

Хүснэгт 1.5.1

№	Төсөллөлтийн үндсэн үзүүлэлтүүд	ЗЗБНБД 22-004-2016 нормын үзүүлэлтүүд	Төсөллөлтийн сонгосон үзүүлэлтүүд
1	Замын ангилал ба зэрэглэл	Зэрэглэл 3А. Байнгын хөдөлгөөнтэй зам	Баянчандмань сумын гэр хорооллыг гол авто замтай холбох авто зам.
2	Жилийн хоногийн дундаж хөдөлгөөний эрчим, Хэтийн хөдөлгөөний эрчим	Хөдөөгийн зам болох багийн төв, фермерийн аж ахуй, аялал жуулчлалын бүс нутаг, хотын захын орон сууц, гэр хороолол. Жилийн хоногийн хөдөлгөөний дундаж эрчим өөр зэрэглэлийн замуудын эрчмийг оруулахгүйгээр 100 -аас бага	-
3	Хүн амын хэрэгцээг хангах байдал	500-аас дээш хүн амтай хот суурин, тосгон болон жуулчдын зорьдог газруудын хэрэгцээг хангах	-
4	Төсөллөлтийн тодорхойлолт	3А-ХО3-БХ-2-50	3А-ХО3-БХ-2-50
5	Тооцоот хурд: Тэгш тал газар	40-50км/ц	40-50
6	Нугачаатай газар	25 км/ц	25
7	Уулархаг	15 км/ц	15
8	Тооцоот хугацаа	15жил	15жил
9	Хөдөлгөөний үйлчилгээний төвши:	Е, F	Е, F
10	Трассын шулуун хэсгийн хамгийн их урт	3500м	327.7
11	Хамгийн их дагуу налуу	5%	3.5

Төв аймгийн Баянчандмань сумын төвийн гэрэл хорооллын чиглэлийн авто замын инженерийн нарийвчласан зураг төсөл

12	Хөдөлгөөний зурвасын өргөн	3.0-3.6м	3.0
13	Хөвөөний өргөн	1.0-2.0м	1.5м
14	Хучилттай зорчих хэсгийн хөндлөн налуу	1.5-2.0%	2.0
15	Далангийн хажуу налуу: Том хэмхдэст ба элсэн хөрс	1:1.5	1:1.5
16	Ухмалын хажуу налуу: Хуурай бус уур амьсгалт бүсийн шавранцар хөрс	1:0.5-1:1.5	-

Төслийн замыг “Авто зам төсөллөх ЗЗБНБД 22-004-2016” нормыг баримтлан төсөллөсөн бөгөөд үндсэн үзүүлэлтүүдийг хүснэгт 1.5.2-д үзүүлэв.

Хүснэгт 1.5.2

№	Тодорхойлолт	Хэмжих нэгж	Үзүүлэлт
1	Замын зэрэг	-	Зэрэглэл 3Б
2	Замын урт	км	1,26
3	Өнцгийн оройн тоо	ш	14
4	Тойруугийн хамгийн бага радиус	м	R=30
5	Тойруугийн хамгийн их радиус	м	R=3000
6	Босоо гүдгэр муруйн хамгийн их радиус	м	R=82373
7	Босоо хотгор муруйн хамгийн бага радиус	м	R=2882
8	Босоо хотгор муруйн хамгийн их радиус	м	R=41782
9	Дагуугийн хамгийн их налуу	%	3.54
10	Замын зорчих хэсгийн өргөн	м	6
11	Хөвөөний өргөн	м	Зүүн 1,5, баруун 1.0
12	Тусгаарлах зурвасын өргөн	м	0,5
13	Явган замын өргөн	м	1.5


ХОЁР: ХЭЭРИЙН ХАЙГУУЛ, ХЭМЖИЛТ, СУДАЛГААНЫ АЖИЛ

2.1 Төслийн бүс нутгийн уур амьсгал, цаг уурын байдал

2.1.1 Замын зурвасын байршил:

Төв аймгийн Баянчандмань сумын төвийн гэр хорооллын чиглэлд шинээр барихаар төлөвлөж байгаа 1.2км урт, хатуу хучилттай замын эхлэл нь Баянчандмань сумын дундуур дайран өнгөрч буй Улаанбаатар- Дархан чиглэлийн авто замын 2-р хэсгийн Км10+620 орчмоос зүүн хойш салаалж Сүүж хайрхан уул чиглэлтэйгээр явах хатуу хучилт бүхий авто зам юм.

Зураг 2.1



2.1.2 Газрын гадарга хотгор гүлгэрийн байдал:

Төв аймгийн баруун хойд хэсэгт: Улаанбаатар хотоос 72 км, аймгийн төвөөс 110 км зайд байрладаг. Улаанбаатар хот болон Төв аймгийн Батсүмбэр, Борнуур, Баянцогт сумтай хиллэдэг. Далайн түвшинээс дээш 1000-1500 м өргөгдсөн. Физик газарзүйн хувьд Хэнтийн захын уулсын мужид, геоморфологийн хувьд Орхон-Сэлэнгийн бэсрэг уулсын мужийн Туулын дэд мужид багтдаг. Газар хөдлөлийн эрчим 7 балл.

2.2 Зам цаг уурын амьсгал:

Судалгааны район нь Монгол орны бусад нутгийн нэгэн адил эх газрын эрс тэс уур амьсгалтай бөгөөд ерөнхийдөө өвөл нь удаан (Цас их унаж хахир хүйтэрнэ), зун нь богино (аагим халуун, хур тундас багаьтар ордог, үе үе цочир хүйтрэн сэрүүсдэг), хавар намар хөндий дагасан хүчтэй шуургатай өдөр олон тохиолддог сэрүүн, хуурайвтар нөхцөлтэй бичил мужид хамаарна.

Монгол орны авто замын уур амьсгал, геотехникийн нөхцлийн ИВ буюу тал хээрийн дэд бүсэд хамаарч

- Ойт хээртээ цасархаг, фас борооноос намаг шавар ихтэй, бороорхог, аянгалаг, хээр талдаа цас нимгэн нягтархаг, малхитай, хахир хүйтэн жаварлаг. Хөрс чулуулаг гүн хөлддөг.
- Газар хөдлөлийн 7 балл байна.


2.3 Агаарын температур

Судалгааны бүс нутагт агаарын температурын олон жилийн дундаж (-0.2 – 2.0°C) байгаа нь агаарын температурын их хэлбэлзэлтэй бүсэд хамаарагдахыг харуулна. Өвөл хүйтэвтэр байх ба хамгийн хүйтэн 1 дүгээр сард -39.6- 42.4°C -т хүрнэ. Хавар 0°C-ыг давж дулаарах хугацаа 3 дугаар сарын сүүлийн 10 хоногт тохиож хамгийн дулаан 7-р сард 30.6-37.5°C -т хүрнэ. Намар 10-р сарын эхний 10 хоногт тохиолдоно.

Агаарт цочир хүйтрэх анхны дундаж хугацаа 9 дүгээр сарын эхний 10 хоногт байх ба хамгийн эрт нь 8 -р сарын 15-аар байна. Харин сүүлийн 10 хоногт хамгийн хожуу нь 6-р Сарын 20-иор тохиож цочир хүйтрэлгүй үеийн үргэлжлэх хугацаа 79-91 хоног байна.

2.4 Хөрсний температур.

Хөрсний гадаргын олон жилийн дундаж температур 2.3- 4.5°C байх ба агаарын температурын жилийн явцтай нэгэн адил 1 дүгээр сард хамгийн хүйтэн (үнэмлэхүй бага температур -39.6 – 48.0°C), 8 дугаар сард хамгийн дулаан (үнэмлэхүй их температур 57.0-63.0°C) байна. Хөрсний гадаргад цочир хүйтрэх анхны хугацаа 9 дүгээр сарын дундуур, сүүлчийн хугацаа 5 дугаар сарын дундуур тохиолддог байна. Хөрсний гүнд 3.2м хүрч хөлддөг ба уг бүс нутагт Хэнтий нурууны уулын тагт орчим нь хөрсний гүнд цэвдэгтэй бүсэд оршино.



Бүсийн дугаар, нэр	Дэд бүсийн индекс	Бүсийн товч тодорхойлолт	Авто замын гео уур амьсгал, гео физикийн онцлог
II Хээрийн авто замын уур амьсгалын бүс	IIВ. Уулын засвар хоорондын тал хээрийн дэд бүс	Бэсрэг уулт хээр, хээр талын авто замын уур амьсгалын хуурай-хүйтэн сэрүүвтэр хахир, хуурайдуу сэрүүвтэр хүйтэн хахирлаг дэд муж.	Олон жилийн цэвдэг чулуулаг алаг цоог тархсан, авто замын уур амьсгалын улирлын хөлдөл-гэсгэлттэй. Уулархаг хээртээ цасархаг, цас бороорхог, аянгалгаг, хээр талдаа цас нимгэн нягтархаг, салхитай хахир хүйтэн жаварлаг

Энэ бүсийн зарим онцлог үзүүлэлтүүдийг доорхи байдлаар үзүүлэв.

Улирлын үргэлжлэх хугацаа

Дэд бүс	Өвөл			Хавар		Зун		Намар
	Эхлэх	Дуусах	Үргэлжлэх хоног	Дуусах	Үргэлжлэх хоног	Дуусах	Үргэлжлэх хоног	Үргэлжлэх хоног
IIВ	25.X-9.XI 2.XI	15-24.III-19.III	126-143 134	6-12.Y-9.Y	45-52 48	6-16.IX 11.IX	110-141 126	43-53 48

Хөрс, агаарын температурын (°C) үзүүлэлт

Дэд бүс	Хөрсний гадаргын температур, °C				Агаар орчны дундаж температур		
	Олон жилийн дундаж	Хамгийн халуун	Хамгийн хүйтэн	0° нэвчих гүн, см	олон жилийн дундаж	Хамгийн хүйтэн сарын	Хамгийн дулаан сарын
IIА	-0...-3	55-60	-44...-55	300-400	-3...-8	-23...-33	15...17

Тайлбар: 0° C нэвчих гүн ул хөрсний төрлөөс хамаарах тул дээд, доод хязгаарыг авна.

Хөрсний хөлдөлт, гэсэлтийн уур амьсгалын хугацаа

Дэд бүс	Хөлдөлт			Гэсэлт		
	Эхлэх	Дуусах	Хоног	Эхлэх	Дуусах	Хоног
IIА	10-20.X 15.X	1.YI-10.YI 20.Y	195-200 197	1-20.IY 10.IY	1.IY-1.YII 15.YI	51-80 65

Авто замын барилгын үйлдвэрлэлийн ажил явуулахад тохиромжтой болон тохиромжгүй улиралын үеүүд

Дэд бүс	Дулааны улирал			Хүйтний улирал
	Эхлэх	Дуусах	Хоног	Хоног
IIА	20.IY	5.X	168	197

Авто замын уур амьсгалын жилийн 4 улиралын салхины хурд, агаарын даралт, харцангуй чийгшил

Дэд бүс	Салхины хурд м/с				Даралт мм Нг баганы өндрөөр	Харцангуй чийгшил, %
	Өвөл	хавар	зун	намар		
IIА	0,7-2,5	2-4	1-2	1-2	550-650	60-70

Төв аймгийн Баянчандмань сумын төвийн гэрэл хорооллын чиглэлийн авто замын инженерийн нарийвчлалсан зураг төсөл

Дэд бүс	Хур тунадасны нийлбэр, мм							
	Өвөл	Хавар	Зун	Намар	Жил	1 хоногт орох борооны хангамж, мм		Борооны хамгийн их орох эрчим мм/мин
						2%	1%	
IIA	10-15	20-70	200-250	25-40	250-350	85	120	1-1,50

Монгол орны автозамын бүсүүдийн хөрсний хөлдөлтийн норматив гүн

Дэд бүс	Хөрсний хөлдөлтийн норматив гүн, м			
	Шавар, шавранцар	Элсэнцэр, тоосорхог элс	Дунд зэргийн элс, хайргархаг элс	Том хэмхдэст хөрс
IIA	2,6	3,1	3,3	3,5

Авто замын уур амьсгалын бүсийн нарны цацраг, нарны гийгүүлэлтийн хэмжээ

Дэд бүс	Нарны цацраг, Мд/м ²			Нарны гийгүүлэл, цаг				
	Нийлбэр	Шууд	Шингэсэн	Жил	XII	YI	XII сарын 1 өдөрт	YI сарын 1 өдөрт
IIA	4500-5200	2400-3200	3000-3700	2800-3100	140-190	280-310	5-6	8-9

Авто замын техник ашиглалтын түвшинд сөргөөр нөлөөлж болох уур амьсгалын үзэгдлүүд, тэдгээрийн үйлчлэл мөчлөгийн хэмжээ

Дэд бүс	Техникийн уур амьсгалын хахир хатуу, балл		Уур амьсгалын хахиршил, балл	Нийт аянгын үйлчлэл		1 аянгийн	
	Хүйтний	Дулааны		Өдрийн тоо	Үргэлжлэл, цаг	Үргэлжлэл, мин	1 км ² талбайн ниргэлтийн тоо
IIA	60-70	25-30	2,5-3,0	30-35	40-50	100-120	6-7

Үргэлжлэл

Дэд бүс	Нойтон цастай		Хялмаатай		Мөстлөгтэй		
	Өдрийн тоо	Үргэлжлэх цаг	Өдрийн тоо	Үргэлжлэх цаг	Өдрийн тоо	Зузаан мм 10 жилд	Зузаан мм 5 жилд
IIA	5-10	4-5	8-10	13-15	1-2	15	10

Үргэлжлэл


Дэд бүс	Ачаалал, кг/м ²		Металлын зэврэлт болох хугацаа, цаг	Тохиромжгүй өдрийн тоо					
	Салхины	Цасны		Халуун	Цасан шуургатай	Шороон шуургатай	Хүчтэй салхитай	Бороотой	цастай
IIA	27-30	60-70	2000-2200	20-30	2-4	3-7	5-10	50-65	40-50

ГУРАВ. ТРАССЫН СОНГОЛТ

3.1 Трассын боломжит газрын судалгаа, байршил тогтоох



Авто замын трасс нь Төв аймгийн Баянчандмань сумын төвийн гэр хорооллын төгсгөл чиглэлд Улаанбаатар -Дархан чиглэлийн авто замын II хэсгийн Км10+620 -аас эхэлж зүүн хойш 1.274км хүртэл үргэлжилж төгсөнө. Хуучин хайрган замын трасс дээр давхцаж хийгдэх тул трассын судалгаа хийгдэх шаардлагагүй. Трассын эхлэл нь Баянчандмань сумын төвийн Х-5341978.168, Y-596138.354 -ээс эхэлж Х-5342999.084 Y- 596885.480 координттай цэгт хүрч дуусна.

Төслийн замын трассыг Төв аймгийн болон Баянчандмань сумын удирдлага, шугам сүлжээний байгууллагуудтай зөвшилцөж төлөвлөө.



Төв аймгийн Баянчандмань сумын төвийн гэрэл хорооллын чиглэлийн
авто замын инженерийн нарийвчлалсан зураг төсөл

Явган хүний зам нь 6см зузаан хавтанг 10см элсэн дэвсгэр дээр хийнэ. Голдоо тусгай хэрэгцээт иргэдэд зориулагдсан хавтантай байна.



ЗУРГАА. ЗАМЫН ТОНОГЛОЛ, ТЭМДЭГЖҮҮЛЭЛТ

6.1 Замын тоноглол, тэмдэг, тэмдэглэгээ

Замын тоноглол хөдөлгөөнийг зохион байгуулах зориулалт бүхий техник хэрэгслүүд хашлага, хашилт, тэмдэг, тэмдэглэгээ, дохионы шон, чиглүүлэх төхөөрөмж, гэрэлтүүлгийн сүлжээ, гэрлэн дохио, хөдөлгөөнийг удирдах автомат систем, зүлэгжүүлэлт, архитектурын байгууламжууд багтана.

Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хөдөлгөөн зохион байгуулалтыг ойлгомжтой болгох зорилгоор дараах ил харааны тэмдэгт, тэмдэглэгээг шаардлагатай газарт байрлуулахаар төлөвлөсөн.

Зураг төсөлд Зам, тээврийн сайдын 2016 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 187 дугаар тушаалаар батлагдсан “Авто зам төсөллөх 33БНБД 22-004-2016”, БНБД 32.01.04-ийн дагуу төлөвлөсөн ба Замын тэмдэгийг техникийн ерөнхий шаардлага MNS 4597:2003 дагуу хийж гүйцэтгэнэ. Үүнд:

i. Замын тэмдэг, тэмдэглэгээ

Замын тэмдэг, тэмдэглэгээ

Авто замын тэмдэг, тэмдэглэгээг төсөллөхдөө MNS ASTM D 4956:2005 “Замын тэмдэгийн гэрэл ойлгогч. Техникийн шаардлага” MNS 4796:2014 “Авто замын тэмдэглэл, техникийн ерөнхий шаардлага”, MNS 4596:2014 “Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм”, MNS 4597:2014 “Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага”, MNS 5613:2006 “Замын байгууламжийн бүтээгдэхүүн. Авто замын тэмдгийн урьдчилан хүчитгэсэн төмөр бетон шон. Техникийн шаардлага”, MNS 4912:2000 “Замын байгууламжийн бүтээгдэхүүн. Авто замын тэмдэг болон дохионы төмөр бетон шон. Техникийн шаардлага” зэрэг стандартуудыг ашигласан болно.

6.2 . Авто замын гарц

Авто замын зогсоол, амрах талбайн төслөлтийг MNS 5879:2012 “Нийтийн тээвэр. Замын зогсоол, ангилал, техникийн шаардлага”-ын дагуу хийсэн.

Тэмдэгийн жагсаалт:

ШИФР: 01/24

Төслийн нэр: Төв аймгийн Баянчандмань сумын төвийн гэр хороолол чиглэлийн
1.2км авто зам

Объект: Баянчандмань сумын төвийн гэр хорооллын 1.2км зам

Анхааруулах тэмдэг	Хориглох тэмдэг	Мэдээлэх, чиглэлийн тэмдэг	Тэмдэгийн хэмжээ, мм	Суурийг бетоноор чигжих, м ³	Хийгдэх тэмдэгийн тоо	Шонгийн голч, м	Тэмдэгийн өндөр, м	Суулгах, м
		5.25	600x900	0.23	44	0.040	3.000	1.200
	2.13		D700	0.23	3	0.040	3.000	1.200
	2.24		D700	0.23	2	0.040	3.000	1.200
1.22			A900	0.23	33	0.040	3.000	1.200
				1.61	82			

ДОЛОО. БУСАД ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ

7.1 Инженерийн шугам сүлжээ

Тус чиглэлийн авто замын хувьд талбай дотор нэг 35кВт-ийн шон, 33ш гэрлийн шон орсон.

Цахилгааны шон 2 цэгт өндөрлөх ба зардлыг төсөвт суулгаж өгсөн. Нарны энергээр ажилладаг гэрлийн 33 шонг шилжүүлж замын тусгаарлах зурваст суулгах ажлын зардлыг төсөвт суулгасан мөн ПК1+40 дээр 150мм голчтой цахилгааны сүвэлгээний хоолой хийхээр зурагт тусгаж ажлын тоо хэмжээнд оруулж өртгийг төсөвт суулгасан болно.

7.2 Археологийн тандалт сүлжээ

Төслийн зам, үйлдвэрлэлийн талбай дотор эртний түүх дурсгалт соёлын өв бүхий газар байхгүй болно.

НАЙМ: ГАЗАР ЧӨЛӨӨЛЛӨЛТ

Газар чөлөөлөлтийн асуудлыг Төв аймгийн Баянчандмань сумын засаг даргын тамгын газар хариуцана. Шилжүүлэх нарны гэрлийн шонгуудыг төсөвт оруулж өгсөн.

ЕС:АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

№	АЖЛЫН НЭР	ХЭМЖИХ НЭГЖ	
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ			
1	Гэр барих	1гэр	2
2	Вагон сууц байрлуулах	1ш	1
3	Контейнер байрлуулах	1ш	1
4	Усны нөөц сав байрлуулах /10тн/	1ш	1
5	Бие засах газар байгуулах /2м*1м/	1ш	1
Замын чиг сэргээх			
6	Замын чигийг сэргээх	км	1.274
ТАЛБАЙН ЦЭВЭРЛЭГЭЭ			
9	Ул хөрсийг тэгшилж нягтруулах	1м2	17100
ГАЗАР ШОРООНЫ АЖИЛ			
10	Зөөлөн материалын ухмал хийж, зайлуулах	1м3	4344.77
11	Зөөврөөр далан байгуулах /2-р зэргийн хөрсөөр/	1м3	480.69
СУУРЬ, ХУЧИЛТЫН АЖИЛ			
12	Авто замын хашлага байрлуулах	у/м	1198.2
13	Хөлдөлтөөс хамгаалах үе, h=0.30м	1м3	2510.15
14	Хайрган хөвөө байгуулах h=0.30м	1м3	942.74
15	Буталсан чулуун суурь байгуулах h=0.20м	1м3	1648.44
16	Шингэн цацлага /prime coat/	1м2	8533.18
17	Асфальтбетон хучилт хийх h=0.05м	1м3	426.66
УС ЗАЙЛУУЛАХ ЭНГИЙН БАЙГУУЛАМЖ			
19	Далангийн хажуу налууг тэгшлэх	1м2	5664.2
20	Өөрийн шуудууг бетоноор /M200/-р бэхлэх h=0.08м	1м3	222.06
21	Уулзварын гадаргууг бетоноор /M200/-р бэхлэх h=0.10м	1м2	80
22	Дренажны нүх ухах h=2.13-2.0 м	1м3	102
23	Дренажны нүхийг 20-40 мм-ийн дайргаар дүүргэх	1м3	102
ЯВГАН ХҮНИЙ ЗАМ			
24	Явган хүний замын хашлага тавих	у/м	2366.43
25	Явган хүний замын суурийг элсээр хийх h=0.10м	1м3	175.65
26	Явган хүний замын хучилтыг хавтангаар хийх	1м2	1805.33
27	Замын тэмдэг суурилуулах	1ш	82
28	Замын тэмдэглэгээг зориулалтын машинаар хийх	м	1200
29	Замын хэвтээ тэмдэглэгээг хийх	1м2	91.55
30	Хурд сааруулагч хийх	ш	5

Шуудуун дээр хийх гарцны ажил

№	Ажлын нэр	Хэмжих нэгж	
30	Дэр бетоны суурийн нүх ухах	1м3	8.96
31	Суурийн нүхийг гараар засах	1м3	0.45
32	Ул хөрсийг нягтруулах	1м2	44.8
33	Сууринд элсэн дэвсгэр хийх 10см	1м3	4.48
34	M350 бетон дэр суурилуулах	1м3	4.32
35	Дэрэн дээр хавтан цутгах	1м3	13.2
36	Хавтанд орох арматурын тоо хэмжээ	кг	758.11

Цахилгааны ажил

№	Ажлын нэр	Хэмжих нэгж	
37	Нарны хавтантай гэрлийн шон шилжүүлэх	1ш	33
38	10кВт -ын шон өндөрлөх	1ш	2
39	150мм голчтой сүвэлгээний хоолой хийх	1м	15,8


 БАТЛАВ
 ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ
 ДАРГА *Мунуу* Д.МӨНХБААТАР

ТӨВ АЙМГИЙН БАЯНЧАНДМАНЬ СУМЫН ТӨВД БАРИГДАХ
 АВТО ЗАМЫН ИНЖЕНЕРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ
 БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

2024 оны 01 дугаар сарын 02-ны өдөр Дугаар №ЗД-2024-01


Зуунмод хот


1	Боловсруулах үндэслэл	Төв аймгийн ИТХ –ын 2023 оны 12 дугаар сарын 4-ны XVII дугаар хуралдааны 03 дугаар тогтоолын 3-р хавсралтын “Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт” -д тусгагдсаны дагуу
2	Төслийн захиалагч	Төв аймгийн Засаг даргын Тамгын газар
3	Байршил	Төв аймаг, Баянчандмань сум
4	Замын техникийн ангилал, замын зэрэг, хүчин чадал	Хуримтлуулагч зам, Зэрэглэл 2А, 3А Хүчин чадал 1.2 км
5	Замын хучилтын хийц	Боловсронгуй төрлийн хучилттай, Хучилтын бүтээцийг тооцоогоор үндэслэнэ
6	Зураг төсөл боловсруулах үе шат, хугацаа	1 үе шаттай 2024 он
7	Төсөл боловсруулах байгууллага	“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” Монгол Улсын хуулийн дагуу сонгон шалгаруулна.
8	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Орон нутгийн замын сангийн хөрөнгө оруулалт
9	Төсөл гүйцэтгэх хугацаа	Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээгээр зохицуулна
10	Баримт бичгийн бүрдэл	Холбогдох бичиг баримтыг /иж бүрэн зураг төсөл/ Эх хувь-1%, Хуулбар-1% өнгөтөөр/, CD-ээр захиалагчид хүлээлгэн өгөх/ pdf өргөтгөлөөр/ Тайлбар бичиг Техникийн шаардлага Техникийн нөхцөл Ажлын иж бүрэн зураг Геологийн судалгааны дүгнэлт Геодези, хэмжилтийн ажлын тайлан Ажлын нэр төрөл, тоо хэмжээ Барилгын ажлын төсөв Авто замын трассд орсон инженерийн шугам сүлжээг шилжүүлэх ажлын зураг төсөл Зураг төслийн иж бүрдэл бүрийг баталгаажуулсан Магадлалын ерөнхий дүгнэлт
11	Төлөвлөлтийн норм	“ Авто зам төсөллөх” ЗЗБД22-004-2016 “Авто замын гүүр ба хоолой төсөллөх” БНБД 32-02-12, Хот суурины гудамж зам төлөвлөлт” БНБД 32-01-0 Автозамын салбарт мөрдөх стандартын замын тэмдэг, тэмдэглэгээ, гэрлэн дохио, хашилт чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм MNS 4596:2014, MNS 4597:2014, MNS 4159:2014, MNS 4980:2014

		<p>Явган хүний зам, талбайн төлөвлөлт. техникийн шаардлага MNS 6808: 2019, “Авто замын барилгын ажлын төсвийн жишиг норм” БНБД81-25-07 “Геодези зураг зүйн тухай” хуулийн 6.1.3 дугаар заалт, “Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл” БНБД 11-07-04-ын II хэсэг инженер геодезийн ажил, “Геодезийн ажил “БНБД 3.01.03-88-д тавигдах шаардлагын дагуу зураг төслийг боловсруулах</p>
12	Онцгой нөхцөл	<p>Хэмжилт зураглалын ажлыг улсын сүлжээний цэгүүдэд тулгуурлан хийх, геодези, байр зүйн зураглалын ажлын иж бүрэн тайланг батлуулан хүлээлгэн өгөх, зам барилгын ажлын үед геометр хэмжээг хангах, хэмжилтийн төсөл-даалгавар боловсруулах. Инженер геологийн судалгаа хийж, хэсэг бүрт хөрсний геотехникийн үзүүлэлтүүдийг нарийвчлан тогтоон замын байгууламжийн бүтээцийг тооцоогоор оновчтой сонгох. Шороон ордын /карьер/ судалгааг дүүргэгч бүрээр тодорхойлж, тооцоолох Автозамын зорчих хэсгийн төлөвлөлтийг огтлолцож буй болон холбогдож буй бүх талын замын төлөвлөлттэй уялдуулах, захиалагчийн саналыг тусгах Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тэмдэг, тэмдэглэгээ, хөдөлгөөн зохицуулалтын тоноглолыг иж бүрэн байдлаар зураг төсөлд тусгах ба зураг төслийг боловсруулахдаа аймгийн Замын цагдаагийн тасагтай зөвшилцсөн байх. Авто зам байршлыг орон нутгийн холбогдох байгууллага болон Засаг даргын тамгын газартай зөвшилцөх, санал авах; Автозам болон уулзварын гэрэлтүүлгүүдийг уулзварт төлөвлөгдөх арал, замын зорчих хэсэг болон явган хүний замыг бүхэлд нь гэрэлтүүлэх орчин үеийн техникийн шаардлагад нийцсэн гэрэлтүүлгийн байгууламжийг сонгох Авто зам, уулзвар болон авто зогсоолын ус зайлуулах байгууламжийг цогц байдлаар шийдвэрлэх Авто замын барилгын ажлын нэгдсэн төсөвт өртөгт Техник технологийн хяналт / Зөвлөх үйлчилгээний зардлыг/ норм нормативын дагуу, түр барилга ба аж ахуйн бэлтгэл ажил, объект ашиглалтад оруулах, хог хаягдал цэвэрлэх, зурваст орсон геодезийн хатуу цэгийг шилжүүлж шинээр байгуулах, лабораторийн туршилт шинжилгээний ажлуудтай холбоотой зардлуудыг заавал тусгах Явган хүний зам, дугуйн замыг норм стандартын дагуу төлөвлөх, захиалагчийн саналыг тусгах Түүх соёлын үнэт өв дурсгал замын трасст орсон тохиолдолд холбогдох байгууллагуудтай зөвшилцөн хамгаалах болон нүүлгэн шилжүүлэх ажлыг эцэслэн шийдвэрлэсэн байна Ажлын зурагт бусад инженерийн шугам сүлжээ орсон тохиолдолд инженерийн бэлтгэл арга хэмжээ, шугам сүлжээний одоогийн байдал болон төлөвлөлтийг нэг дэвсгэр зураг дээр нэгтгэн, хоорондын зай хэмжээг огтлолын зургаар тодорхой үзүүлж, норм стандартын дагуу төлөвлөж, шугам сүлжээний ашиглалтын байгууллагуудтай зөвшилцсөн байх шаардлагатай Газар хөдлөлтөөс үзүүлэх нөлөөллийг тооцох; Замын барилгын ажлын явцад тээврийн хөдөлгөөнийг саадгүй явуулах түр замын ажлын хэмжээг гаргаж, зураг төсөвт тусгах;</p>


		Зургийн байгууллага хариуцлагын даатгалд хамрагдсан байх; Нарийвчилсан зураг төслийн иж бүрдлийг Захиалагчаар хянуулж, зөвшилцсөний дараа магадлалд оруулна.
13	Инженерийн дэд бүтцэд тавигдах шаардлага	Инженерийн бэлтгэл арга хэмжээ: Үерийн хамгаалалтын сувагт нийлэх гуу жалга, түүний ус хүлээн авах барилга байгууламжийг төлөвлөх Цахилгаан хангамж, гэрэлтүүлэг: Цахилгаан хангамжийн болон гэрэлтүүлгийн ажлын зураг төсөлд орон нутгийн мэргэжлийн ашиглагч байгууллагуудын саналыг тусгаж, хянуулж батлуулах <u>Гадна холбооны сувагчлал:</u> Ашиглагч байгууллагаас хүргүүлсэн техникийн даалгаврын дагуу "Мэдээлэл Холбооны Сүлжээ" ТӨК-ний үндсэн сувагчлалыг төлөвлөж буй авто замтай уялдуулан төлөвлөх;
14	Зөвшилцөх байгууллага	Төв аймгийн ЗДТГ, Сэргэлэн сумын ЗДТГ, Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг, Аймгийн онцгой байдлын газар, Бусад инженерийн шугам сүлжээ хариуцсан холбогдох байгууллагууд

ХЯНАСАН:

ЗДТГ-ЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО
ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА  Д.САРАН-ЭРДЭНЭ

АЙМГИЙН ГХБХБГ-ЫН БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА АЙМГИЙН
ЕРӨНХИЙ АРХИТЕКТУР  Д.АЛТАНСҮХ

БОЛОВСРУУЛСАН:

ЗДТГ-ЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО
ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН  Я.ПАГАМААЖАВ



**ТӨВ АЙМГИЙН
БАЯНЧАНДМАНЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/45

Эх Сүж

Засаг даргын Тамгын газарт газар
эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол улсын Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2, 28.1.1, 29.1 дэхь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засаг даргын Тамгын газар /9059628/ нь Дэд бүтцийн зориулалтаар газар эзэмших хүсэлт ирүүлсэнийг үндэслэн Замт 2 дугаар баг Сүж 1 дүгээр гудамжны уулзвараас суварганы энгэрийн уулзвар хүртэлх 1.2 км авто замын барилгын ажил хийх зориулалтаар 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.
2. Байгаль орчинг хамгаалах газрыг гэрээнд заасны дагуу, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр газрыг эзэмших, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг 90 хоногт багтаан хийлгэх, кадастрын зураг хийлгэх, ноогдуулсан газрын төлбөрийг улирал бүрийн 25-ны дотор төлж байхыг ЗДТГ-ын дарга (А.Мөнхтуул)-д даалгасугай.
3. Газар эзэмшигч иргэнд газрыг хэмжиж тэмдэгжүүлж, кадастрын зураглалын мэдээллийн санд бүртгэх, газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээжүүлэхийг Сумын газрын даамал (М.Алтантуяа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АРИУНБОЛД

Бүртгэлийн дугаар 12
ТӨВ АЙМГИЙН БАЯНЧАНДМАНЬ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
2024 оны 02 сарын 19



**ТӨВ АЙМГИЙН
БАЯНЧАНДМАНЬ СУМЫН
ЗАСАГ ДАРГА**

41160, Төв аймаг, Баянчандмань сум
Утас: 70276329


Цахим илгээг: bayanchandmanituv@gmail.com

2024.08.27 № 01/99
танай _____ -ны № _____ -т

**ТӨВ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА
БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАРТ**

“Буман Од Пикет” ХХК-ийн гүйцэтгэж байгаа сумын төвийн доторх гэр хорооллын 1.2 км хатуу хучилттай авто замын трасст орж байгаа нэгж талбаруудыг чөлөөлөх ажлыг хийж гүйцэтгэнэ.

ЗАСАГ ДАРГА



Г.АРИУНБОЛД

4124050108

МЭДЭГДЭХ ХУУДАС

Дугаар 17

2024 оны 02-р сарын 27-ны өдөр

Ч.Наст га

Газар чөлөөлөх тухай

Таны **Замт 2 дугаар баг Сүж** гэх газарт байршилтай өмчлөх эрхтэй, мэдээллийн санд баталгаажилт хийгдсэн **4116039563** нэгж талбарын дугаартай газар нь: Сумын төв дотор тавих авто замын трасстай давцсан тул газар чөлөөлөх болон хашаагаа газрын кадастрын зургийн дагуу болгох хашаагаа татахыг мэдэгдэж байна.

“Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 12.1.7, Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3.2.газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах тухай хууль тогтоомж болон төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэх сумын Засаг дарга уг газрыг чөлөөлөх тухай хугацаатай мэдэгдэл өгнө.” гэж заасны дагуу хугацаатай мэдэгдэл хүргүүлж байна.

Энэхүү мэдэгдлийг хүлээн авсан 2024 оны 03-р сарын 04-ний өдрөөс хойш 30 хоногийн дотор чөлөөлөхийг мэдэгдье.

Мэдэгдэлд заасан хугацаанд чөлөөлөөгүй тохиолдолд Газрын тухай хуулийн 57.4 дахь заалтад “Мэдэгдэлд заасан хугацаанд газрыг чөлөөлөөгүй бол аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга уг газрыг албадан чөлөөлөх арга хэмжээ авч, холбогдох зардлыг гэм буруутай этгээдээс гаргуулна.” гэж заасны дагуу албадан чөлөөлөх арга хэмжээг авна.

БАЯНЧАНДМАНЬ СУМЫН

ГАЗРЫН ДААМЛА

М.АЛТАНТУЯА

Дугаар _____

Шаардах хуудсыг хүлээн
авсан.....

(албан тушаал, нэр)

Хаяг.....

(гарын үсэг)

2024 оны-р сарын-ны өдөр

Дугаар 01.

Шаардах хуудсыг хүлээн
авсан шаардах хуудсаа хүлээн авчээ.

Н.Одонт
(албан тушаал, нэр)

Хаяг Залет баг 4 хороо сум 915

Н.Одонт
(гарын үсэг)

2024 оны 02-р сарын 09-ны өдөр

Дугаар _____

Шаардах хуудсыг хүлээн
авсан Лундга Заатарчигем

Лундга Заатарчигем
(албан тушаал, нэр)

Хаяг Залет баг сум 9-1а

Баасарчигем
(гарын үсэг)

2024 оны 02-р сарын 09-ны өдөр

Дугаар 03

Шаардах хуудсыг хүлээн
авсан Энх сайхан Э.Тамхайр

(албан тушаал, нэр)

Хаяг Эрдэнэ 3-р баг

(гарын үсэг)

2024 оны 2-р сарын 29-ны өдөр

Дугаар 07

Шаардах хуудсыг хүлээн
авсан Мандаг овогтой Бадмаа

(албан тушаал, нэр)

Хаяг Замт баг Зураагч 5-2 шүүм

99259586

96230370

(гарын үсэг)

2024 оны 02-р сарын 29-ны өдөр

Дугаар 08.

Шаардах хуудсыг хүлээн авсан Талсанбатшир - Монгол УИХ

Хаяг Золт бай (албан тушаал, нэр) Чураанхайн дайро
4-1 тосот

(гарын үсэг) МОН

2024 оны 2-р сарын 29-ны өдөр

Дугаар 11

Шаардах хуудсыг хүлээн авсан Салдан Оелтой Бүжигмаарал

Хаяг Золт бай сум (албан тушаал, нэр) 8,1 тосот
85113404.

(гарын үсэг)

2024 оны 02-р сарын 29-ны өдөр



ТӨВ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР
АВТО ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛД ХЯНАЛТ
ХИЙСЭН ТУХАЙ ДҮГНЭЛТ

213300 Зуунмод, Төв аймаг,
Утас: 70273793, 70273060
E-mail: tuv_emer@yahoo.com

2024.03.06

№

09/
11

Нэг. Авто замын ажлын зураг төслийн мэдээлэл

1. Барилга байгууламжийн байршил: Төв аймгийн Баянчандмань сумын төвийн доторхи гэр хороолол чиглэлийн 1,2 км хатуу хучилттай автозамын ажлын зураг.
2. Зургийн шифр, зураг төслийн компани: Шифр: 01/2024 "Буман од пикет" ХХК.
3. Барилга байгууламжийн зориулалт: Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын захиалсан Баянчандмань сумын төвийн доторхи гэр хороолол чиглэлийн 1,2 км хатуу хучилттай автозамын ажлын зураг.
4. Авто замын талбай, эзлэхүүн: L-1,2 км
5. Үндсэн хийц бүтээц: Автозамын зорчих хэсэг 6 метр, 1 үе асфальтобетон хучилттай, зүүн талдаа 1 метрийн хөвөөтэй, баруун талдаа 1,5 метрийн өргөн явган хүний замтай, 0,5 метрийн тусгаарлах зурвастай төлөвлөсөн.
6. Зургийн иж бүрдэл: 1 хэсэг

Хоёр. Авто замын аюулгүй байдал

1. Авто замын зураг төсөл боловсруулахдаа хадархаг хөрс чулуулгийн бүтэц, түүний усжилт, хийжилт, болон байгалийн хүчдэлийн төлөв зэргийг нэмж тооцох;
2. Усны хаалтын тэнхлэгийн чиглэлд хайрган гадарганы тогтворийг сайжруулах ба бетонон хийцээр хүчитгэх;
3. Авто замын стандарт, нормийг мөрдөж ажиллах.

Дээрх шаардлагыг биелүүлснээр авто замын зураг нь үерийн аюулаас урьдчилан сэргийлэх шаардлагыг хангаж байгаа болно. /Ажлын зураг дээр зөвшилцөн засаж, нормын дагуу засвар хийгдсэн зургаар авто замын угсралтын ажлыг гүйцэтгэсэн байх шаардлагатай/.

Барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах тохиолдолд Онцгой байдлын байгууллагатай зөвшилцөж шийдвэрлэнэ.

Зөвшөөрсөн сар, өдөр	Зөвшөөрлийн тэмдэг дарсан хуудасны дугаарууд	Нэмэлт тэмдэглэл
2024.03.04	Тойм зураг-2, Тахир муруйн хүснэгт-5, Дэвсгэр зураг-1, Хөндлөн огтлол-0,	Авто замыг зураг төслийн дагуу гүйцэтгэх

ДУГНЭЛТ ГАРГАСАН,
ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧ,
ДЭСЛЭГЧ



Д.ТЭГШБАЯР



МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ
ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
ТӨВ АЙМГИЙН ГАЗАР

Төв аймаг 41111, Зуунмод сум
Номт баг, Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ийн байр,
Утас/факс: (976)-70272110
И-мэйл: tuv@ionc.mn, http://www.ionc.mn

2024.02.07 № 24/18
танай 2024.01.29-ны № 03/24 -Т

БУМАН ОД ПИКЕТ ХХК

Төв аймгийн Баянчандмань сумын нутаг дэвсгэрт шинээр баригдах авто замын трасст манай кабель шугамын байгууламж байхгүй болно.



ДАРГА Т.АРИУНБОЛД



112/0310
D.MXC ХХК Тув аймаг/албанбичиг/A5